

14230 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Парисын гудамж 42, Ай Си Тауэр, 14 давхар

Утас: +976 7709-0077  
И-мэйл: info@invescore.mn  
Веб сайт: www.invescore.mn

2026.04.17 № А/206  
танай \_\_\_\_\_-ны \_\_\_\_\_-т

## Мэдээлэл хүргүүлэх тухай

Инвескор ББСБ ХК /РД:6060854/ нь 2026 оны 02 сарын 13-ны 08 болон 09 тоот тогтоолуудын хүрээнд энгийн болон давуу эрхийн хувьцаа эзэмшигч нартаа, 2026 оны 4 сарын 20-ны өдөр ногдол ашиг тараахаар Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэсэн.

Үйл ажиллагаагаа тэлэх, харилцагч, хөрөнгө оруулагчдад хүртээмжтэй хүрч үйлчлэх хүрээнд бид олон улсын банк, хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө оруулалт, зээл татан төвлөрүүлж ажилладаг бөгөөд үйл ажиллагааны хугацаанд тогтмол дагаж мөрдөх санхүүгийн үзүүлэлтийн болоод санхүүгийн бус үүргийг хүлээдэг.

Бид бүхэн ногдол ашиг тараах шийдвэр гаргахын хувьд Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөн, зохих шаардлагыг хангасны үндсэн дээр олгох шийдвэр гаргахаас гадна дээрх хөрөнгө оруулалт, зээлийн гэрээнүүдээр хүлээсэн үүргийн хүрээнд зээлдүүлэгч нараас зөвшөөрөл авсны үндсэн дээр ногдол ашиг тараах үүргийг хүлээдэг.

Бидний санхүүгийн нөхцөл байдал ногдол ашиг тараах боломжтой гэж үзсэн хугацаанаас эхлэн одоог хүртэл бид олон улсын зээлдүүлэгчдээс ногдол ашиг тараах талаар тухайлсан гэрээнд заасан нөхцөлөөр зөвшөөрөл авахаар ажилласаар байгаа хэдий ч биднээс үл хамаарах шалтгаан буюу зээлдүүлэгчдийн үйл ажиллагааны онцлог, шийдвэр гаргах эрх бүхий дотоод албан тушаалтан, хурлын процессын, шийдвэр гаргах хугацааны ялгаатай байдлуудаас үүдэн ногдол ашиг төлөхөөр шийдвэрлээд байсан 2026 оны 4 сарын 20-ны өдрийн дотор зарим зээлдүүлэгч нар зөвшөөрлөө өгч амжихгүй гэдгээ мэдэгдээд байна.

Бид дээрх гэрээнүүдээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд зөвхөн тухайн зээлдүүлэгчийн гэрээний хувьд зөрчил гаргасан төдийгүй нэг зээлдүүлэгчийн гэрээний зөрчлийг үндэслэн бусад бүх зээлдүүлэгч нар гэрээний зөрчил зарлах эрхтэй буюу хэрэгжүүлэх боломжтой нөхцөл байдал үүсээд байгаа ба ийнхүү зарлах нь Компанийн цаашдын үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүслээ.

Бид урт хугацаандаа хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдийнхээ эрх ашгийг хамгаалах үүднээс ногдол ашиг тараах өдрийг 3 сарын хугацаа буюу 2026 оны 7 сарын 31-ны өдрийн дотор, ингэхдээ зээлдүүлэгчид холбогдох зөвшөөрөл өгсөн даруй төлөх байдлаар хойшлуулахаар шийдвэрлэсэнээ үүгээр мэдэгдэж байна.

Хэдийгээр үүссэн нөхцөл байдлын улмаас ийнхүү шийдвэрлэж байгаа хэдий ч бид холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн шаардлагатай бүхий л мэдээллээр хувьцаа эзэмшигчдээ хангах үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх болно.

Хамтран ажилласанд талархал илэрхийлье.

ХҮНДЭТГЭСЭН,  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ОРОЛМАА

1002601430

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04-р сарын 17-ны өдөр

№ 26/21

Улаанбаатар хот

*Ногдол ашиг тараах өдөрт өөрчлөлт оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсгийг үндэслэн  
**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудаас тэдгээртэй байгуулсан санхүүжилтийн гэрээний дагуу Компани ногдол ашиг тараах тухай зөвшөөрөл бүрэн ирээгүй байгаатай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 сарын 13-ны өдрийн 08 болон 09 дугаар тогтоолд заасан ногдол ашиг тараах өдрийг 3 сар хүртэлх хугацаагаар буюу 2026 оны 07 сарын 31-ний өдөр хүртэл хойшлуулсугай.
2. Энэхүү тогтоолоор өөрчлөлт оруулсан ногдол ашиг тараах өдрөөс бусад харилцаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 сарын 13-ны өдрийн 08 болон 09 дугаар тогтоолуудыг дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү тогтоолыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, эрх бүхий зохицуулагч байгууллагуудад мэдээлэх, ногдол ашиг тараах өдрийг хойшлуулах болсон шалтгаан нөхцөлийг тайлбарлах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Оролмаа/-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ДАРГА**

